**УЛСЫН МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

# 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот, 2025 он

## 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Үндсэн чиг үүрэг | Стратеги | Зорилтын тоо | Арга хэмжээ |
|---|---|---|---|
| Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори (УМЭАЦТЛ, УТҮГ) | Нэгдүгээр хэсэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ | 1 | 21 |
| | Хоёрдугаар хэсэг. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах | 1 | 3 |
| | Гуравдугаар хэсэг. Хуулиар олгогдсон тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх | 1 | 8 |
| | Дөрөвдүгээр хэсэг. Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх | 1 | 32 |
| **Нийт зорилт, арга хэмжээ** | | **4** | **64** |

# НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

**УЛСЫН МАЛ ЭМНЭЛЭГ АРИУН ЦЭВРИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**
**2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

| Арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь (%) |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1.1 Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн салбарт хамаарах зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>Дэд зорилт. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, тархварзүй мэдээлэл судалгаа статистик | | | | | | |
| 1.1.1 Стандарт, аргазүй, шинэчлэн боловсруулах, нэвтрүүлэх | Улсын төсөв | 1. Өөрчлөлт оруулахаар боловсруулсан MNS стандартын тоо<br>2. Нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсан стандарт ажиллагааны зааврын тоо | 1.0<br>2.0 | 1.3<br>2.3 | Монгол улсын хэмжээнд хүчингүй болсон мал, амьтны халдварт өвчний оношилгооны MNS стандарт 3-ыг шинэчлэн боловсруулж, стандарт хэмжилзүйн газрын хөдөө аж ахуйн стандартчилалын техникийн хороонд батлуулахаар хүргүүлсэн.<br>Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний полимеразийн гинжин урвал (ПГУ)-ын 5, бодит цагийн ПГУ-ын 2, эсрэгтөрөгч илрүүлэх ЕЛИЗА урвалын 1, сүүлийн үеийн дэвшилтэт технологи Нанапор минон багажид бактери болон вирусийн геномын мэдээлэл тодорхойлох 1, мал, амьтны эцэг эх тодорхойлох ген секвинсингийн 1 нийт 9 стандарт ажиллагааны заавар (САЗ) боловсруулж батлуулан, байгуулагын хэмжээнд мөрдөж эхлэв.<br>Хятад улсын зооноз өвчин судлалын үндэсний хүрээлэнтэй хамтын ажиллагааг эхлүүлж, зоонозын халдварт Бруцеллёз, Боом халдварт өвчнийг богино хугацаанд оношлох КОЁОТО багаж болон шинэ цомог ашиглаж харьцуулан туршсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.1.2 Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, тандалт зохион байгуулах | Улсын төсөв | 1. Удирдамжийн тоо | 1.4 | 1. 4 | Мал, амьтны гоц халдварт 4 төрлийн өвчин (шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах)-ний халдварын тандалт судалгааны удирдамж, аргазүйг боловсруулж МЭЕГ-ын Тархварзүй, мэдээлэл статистикийн газарт хүргүүлсэн.<br>Тайлбар: Сангийн яамны төсвийн тодотгол, санхүүжилтийн хязгаарлалтаас шалтгаалан тандалтын ажил хийгдэж эхлээгүй байна. | 50% |
| 1.1.3 Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын дараах тандалт зохион байгуулах | Улсын төсөв | 1. Удирдамжийн тоо | 1.4 | 1. 4 | Мал, амьтны гоц халдварт 4 төрлийн өвчин (шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах)-ний вакцин тариагдсаны дараах дархлаажуулалтын үр дүнг үнэлэх, тандалт судалгааны ажлын удирдамж, аргазүйг боловсруулж МЭЕГ-ын Тархварзүй, мэдээлэл статистикийн газарт хүргүүлсэн.<br>Тайлбар: Сангийн яамны төсвийн тодотгол, санхүүжилтийн хязгаарлалтаас шалтгаалан тандалтын ажил хийгдэж эхлээгүй байна. | 50% |
| 1.1.4 Мал, амьтны халдварт, зооноз, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах | Улсын төсөв | 1. Удирдамжийн тоо<br>2. Нэвтрүүлсэн аргазүйн тоо | 1.7<br>2. 1 | 1.7<br>2.3 | Гахай, шувуу, зөгий, нуур голын загасанд мал, амьтны гоц халдварт, халдварт зоонозын гаралтай өвчнүүдийг илрүүлэх, тандах, шинэ болон дахин сэргэж буй өвчнийг эрт илрүүлэх, лабораторийн дэвшилтэт технологи ашиглан шинжилгээг гүйцэтгэх, үр дүнд суурилан оношилгооны бэлэн байдлыг хангах зорилгоор тандалт судалгааны удирдамж, аргазүйг боловсруулан МЭЕГ-ын Тархварзүй, мэдээлэл статистикийн газарт хүргүүлсэн.<br>Тайлбар: Сангийн яамны төсвийн тодотгол, санхүүжилтийн хязгаарлалтаас шалтгаалан тандалтын ажил хийгдэж эхлээгүй байна. | 50% |
| 1.1.5 Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах | Улсын төсөв | 2. Удирдамжийн тоо | 1.2 | 1. 2 | “Адууны халдварт 4 өвчин (Адууны халдварт цус багасах, нийлүүлэг, ям, африкийн мялзан) тандалт судалгааг 3380 сорьц түүвэрлэж зохион байгуулах, өвчин тус бүрийн халдварлалтын түвшинг улсын хэмжээнд | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоох тандалтын ажлын удирдамж аргазүйг боловсруулан МЭЕГ-ын Тархварзүй, мэдээлэл статистикийн газарт хүргүүлсэн.<br>Тайлбар: Сангийн яамнаас хийх төсвийн тодогол, санхүүжилтийн хязгаарлалтаас шалтгаалан тандалтын ажил хийгдэж эхлээгүй байна. | |
| 1.1.6 Мал, амьтны халдварт, зооноз, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх | Улсын төсөв | 1. Удирдамжийн тоо<br>2. Сорьцын тоо | 1.1 | 1. 1 | Бруцеллёзын вакцинжуулалтын дараах хяналт, вакцин таригдсаны дараах дархлаажуулалтын үр дүнг үнэлэх тандалт судалгааны ажлын удирдамж, аргазүйг боловсруулж МЭЕГ-ын Тархварзүй, мэдээлэл статистикийн газарт хүргүүлсэн. | 50% |
| 1.1.7 Зүүн аймгуудад тохиолдож буй малын хорогдлын шалтгааныг тогтоох тандалт зохион байгуулах | Улсын төсөв | Тандалтын тоо | 1.0 | 1.1 | Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн зарим сумдад тохиодож буй үхрийн хорогдлын шалтгааныг тогтоох тандалтын ажлыг МЭХүрээлэнтэй хамтран зохион байгуулах удирдамж, аргазүйг боловсруулж МЭЕГ-ын мал,амьтны эрүүл мэндийг хамгаалах газарт хүргүүлсэн. | 50% |
| 1.1.8 Шуурхай дуудлага үйлчилгээ үзүүлэх | Улсын төсөв | 1. Хариуг хүргүүлсэн хугацаа,<br>2. Гүйцэтгэл | 72 цаг | 48 цаг | Дорноговь аймгийн Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ сумдын нутгаас зээрийн өвчлөл хорогдлын шалтгааныг тогтоох зорилгоор өвчилсөн зэрлэг амьтдаас лабораторийн шинжилгээнд дээж авах, онош тодруулах зорилгоор 4 хоног томилолтоор ажиллаж, хоргодлын шалтгаан нь зэсийн дутал (оронги) өвчин болохыг тогтоож, хариуг 48 цагт багтаан тус аймгийн МЭГ, МЭЕГ-т хүргүүлсэн. | 50% |
| 1.1.9 Бичил биетний тэсвэржилтийн тандалт зохион байгуулах | | 1. Төлөвлөгөө батлуулах | 1.1 | 1.1 | Бичил биетний тэсвэржилтийн тандалт хийх төлөвлөгөөг МЭЕГ-ын 2025 оын тандалтын төлөвлөгөөнд тусган батлуулж, тандалтанд шаардагдах зардлын тооцоог, боловсруулсан удирдамж, аргазүйн хамт МЭЕГ-т хүргүүлсэн. | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ББТ-ийн олон улсын ATLASS үнэлгээнд 2025 оны 05 сарын 19 нд 2 дахь удаагаа амжилттай хамрагдлаа. | |
| 1.1.10 Мал, амьтны эмийн үлдэгдлийн тандалт зохион байгуулах | | Удирдамжийн тоо | 1.1 | 1.2 | 21 аймаг, нийслэл 330 сумын хэмжээнд малын эмийн үлдэгдлийн тандалт зохион байгуулах, газар тариалангийн бүс нутагт буй мал, амьтанд пестицидийн үлдэгдлийн тандалт судалгааг зохион байгуулах дээжийн тооцоолол бүхий арга зүйн удирдамж боловсруулж МЭЕГ-т хүргүүлсэн. | 50% |
| 1.1.11 Дотоод болон гадаадын зах зээлд нийлүүлж буй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийх | Улсын төсөв | Сорьцын тоо | | | Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох нийт 5 төрлийн шинжилгээ (нян судлал, ариун цэвэр, магадлан шинжилгээ, цацрагийн бохирдол, эмийн үлдэгдэл, мөөгөнцөр) 1899 хандалтаар 2826 сорьц хүлээн авч 8607 дээж болгон бэлтгэж итгэмжлэлийн хүрээний 23510 үзүүлэлтээр шинжилгээг хийж гүйцэтгэсэн (44 сорьцонд 51 эерэг үзүүлэлт).<br>Эерэг сорьцын мэдээллийг МЭЕГ-т хүргүүлж ажилласан.<br><br>ХЭАҮШЛ-д ирүүлсэн хүнсний аюулгүй байдлын баталгаажилт олгох зорилгоор шинжлэгдсэн нийт сорьцын дийлэнх хэсгийг экспортын зорилготой сорьц эзэлж байна. Харин хамгийн бага нь импортын шинжилгээ байна. Үүнд:<br>Экспорт - 1266<br>Дотоод хяналт - 970<br>Импорт - 537<br>Лабораторид ирүүлсэн сорьцын төрлөөр мах, махан бүтээгдэхүүний сорьц дийлэнх хувийг эзэлж байна. Үүнд сорьцын тоо нь:<br>1452 - Мах<br>353 - Махан бүтээгдэхүүн<br>305 - Чанасан мах | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 259 - Дайвар бүтээгдэхүүн<br>115 - Тос<br>80 - Сүү, Сүүн бүтээгдэхүүн<br>62 - Далайн гаралтай бүтээгдэхүүн<br>61 - Өндөг, өндгөн бүтээгдэхүүн<br>30 - Бусад<br>29 - Ясны шөл<br>19 - Ясны буталмал, гурил, эвэр, яс<br>18 - Амьтны тэжээл<br>4 -Хагас боловсруулсан бүтээгдэхүүн<br>тус тус байв. | |
| 1.1.12 Импортын зорилгоор хүлээн авсан гахай, тахианы махны хүнсний аюулгүй байдлын баталгаажилт олгох | | | | | Имдортоор оруулж ирсэн гахай (5) тахиа (365)-ны мах, махан бүтээгдэхүүний нийт 400 сорьц хүлээн авч хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох нийт 4 төрлийн шинжилгээг (нян судлал, ариун цэвэр, магадлан шинжилгээ, цацрагийн бохирдол, эмийн үлдэгдэл) 1858 дээж болгон бэлтгэж итгэмжлэлийн хүрээний 4162 үзүүлэлтээр шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний үр дүнд эерэг үзүүлэлт байхгүй байна. | 100% |
| Тархвар зүй, мэдээлэл судалгаа, статистик | | | | | | |
| 1.1.13 Мал эмнэлгийн лабораторийн чадавх, тандалтын тогтолцоог сайжруулах | | 1.Удирдамжийн тоо<br>2. Сүлжээ лабораторийн хэмжээнд зохион байгуулсан сургалтын тоо | 1.18<br>2. 8 | 1. 22<br>2. 6 | Мал, амьтны гоц халдварт, халдварт, зооноз, эмийн үлдэгдэл, бичил биетний тэсвэржилтийн халдварын болон вакцины дараах тандалтын эпидемиологийн дээжийн тооцоолол бүхий нийт 22 удирдамж аргазүй боловсруулж, 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторит хүргүүлсэн.<br>21 аймаг, нийслэлийн сүлжээ лабораторийн шинжлэгч эмч нарын ур чадварыг сайжруулах, тандалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зориулж, лабораторийн дотоод сүлжээгээр дамжуулан, онлайн хэлбэрийн нийт 6 удаагийн сургалт зохион байгуулсан. | 100% |
| 1.1.14 Мал эмнэлгийн лабораторийн | | 1. Оношлуур, эм урвалж захиалгын тоо | 1. 2<br>2. 20% | 1.3 | 2024 оны 6 дугаар сарын 10-нд УМЭАЦТЛ төдийгүй 21 аймаг, нийслэлийн лабораторит 2025 онд шинжилгээнд ашиглах оношлуур эм | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| оношилгоо, шинжилгээний бэлэн байдлыг хангах | | 2. Шинжилгээ хийх боломжит хувь | | 2. 35 % | урвалж, багаж тоног төхөөрөмжийн захиалгыг гарган МЭЕГ-т хүргүүлсэн.<br>Тайлбар: Хагас жилийн байдлаар МЭЕГ-аас нийлүүлэлт хийгдээгүй байна. | |
| 1.1.15 Мал эмнэлгийн лабораторийг чадавхжуулах (сургалт, итгэмжлэл) | | 1. 21 аймаг, нийслэлийн эмч ажилтанг сургах дадлагажуулах<br>2. Итгэмжлэлд хамруулах лабораторийн тоо | 1.16<br><br>2.7 | 1.9<br><br>2.9 | УМЭАЦТЛ хагас жилийн байдлаар 7 аймгийн нийт 9 шинжлэгч эмчид (Дорноговь аймгийн 2, Дундговь аймгийн 1, Говьсүмбэр аймгийн 2, Төв аймгийн 1, Ховд аймгийн 1, Хөвсгөл аймгийн 1, Завхан аймгийн 1) лабораторийн биоаюулгүй байдлын болон хүнсний нян судлал, эминй үлдэгдэл, ийлдэс судлал болон молекул биологийн дадал эзэмших ажлын байрны сургалтанд хамрагдсан. Сургалтанд хамрагдсан эмч тус бүрт гэрчилгээ олгосон.<br>2025 онд итгэмжлэлд хамрагдах нийт 4 аймагт (Баянхонгор, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай) ISO-17025 стандартын баримт бичигт тавигдах шаардлагын дагуу мэргэжил, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллав.<br>Түүнчлэн МАЭМТХуульд заасны дагуу мал эмнэлгийн сүлжээ лабораториудыг нэгдсэн журмаар итгэмжлэдэг болгох саналын хүрээнд 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори тус бүрээс итгэмжлэлтийн хүрээ, дотоод аудитын тайлан болон өргөдлийн маягтыг авч нэгтгэн МЭЕГ-т хүргүүлэв. | 100% |
| 1.1.16 Өвчний эмнэл зүйн шинж тэмдэгт суурилсан тандалт, дэгдэлтийн судалгаа | | Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед тархвар зүйн судалгаа хийх, тоо | 1.2 | 1.1 | Дорнод аймгийн Цагаан оюо суманд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин оношлогдсонтой холбогдуулан МЭЕГ-аас томилогдсон мэргэжлийн багт ажиллаж, голомтын дэгдэлтийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Дэгдэлтийн судалгаанд үндэслэн яаралтай үеийн тандалтыг зохион байгуулж, эмнэлзүйн шинж тэмдэгтэй голомтын бүсийн мал болон сэжигтэй, эрүүл бүсийн малаас ийлдэс, арчдасны сорьц цуглуулан лабораторийн шинжилгээнд хамруулж, | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тандалтын үр дүнг МЭЕГ-т шуурхай хүргүүлж ажилласан. | |
| 1.1.17Лабораторийн болон тандалтын цахим мэдээллийн систем (ЛИМС)-ийн хэрэглээ болон өгөгдлийн санг өргөжүүлэх, хөгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг сайжруулах, аюулгүй байдлыг хамгаалах | Улсын төсөв | 1. Шинжлгээний системд хөгжүүлэлт хийх тоо<br>2. Тандалтын системд хөгжүүлэлт хийх тоо | 1.0<br>2.0 | 1.11<br>2.25 | Лабораторийн цахим системд өгөгдөл оруулахад гарсан асуудлыг тухай бүр залруулж ажилласан.<br>Лабораторийн систем болон тандалтын системийн зарим өгөгдөлд хөгжүүлэлт хийлгэх, нэмэлт санхүүжилт шаардагдах тухай санал боловсруулан МЭЕГ-т албан бичгээр 2 удаа хүргүүлсэн. Кибер аюулгүй хамгаалалын үүднээс мөн системийн аюулгүй байдлыг хамгаалалтын ажил хүрээнд хөгжүүлэлт шаардлагатай байгаа. | 50% |
| 1.1.18 Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангах зорилтын хүрээнд системийн хэвийн үйл ажиллагааг хангах болон байгууллагын компьютер, програм хангамжийг лиценжүүлэх | Улсын төсөв | 1. Системийн хэвийн үйл ажиллагаа, тохиргоо болон доголдолын тоо,<br>2. Ашиглаж эхэлсэн албан ёсны лиценз бүхий програм хангамжийн тоо, | 1.<br>2.0 | 1. 75<br>2.0 | Системийн хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд дараах ажил гүйцэтгэсэн.<br>-Тайлант хугацаанд нийт 73 удаагийн тохиргоо болон 2 удаагийн доголдолын залруулсан байна.<br>Лиценцтэй програм, хангамжийн тоо-0 | 50% |
| 1.1.19 Мэдээллийн болон хяналтын хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах | Улсын төсөв | 1. Хяналтын камер шинэчилэх<br>2.Компьютер, принтерийн залруулах ажлыг нийт 15 удаа гүйцэтгэсэн. | 1.0<br>2.18 | 1.1<br>2.15 | Байгуулагын камер шинэчлэх буюу MNS стандарт хангасан камераар камержуулах, NVR төхөөрөмжийг солих ажлыг “ST solution” ХХК-тай хамтран зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд нийт 32 камер (гадна талд 14, дотор талд 18) суурилуулан, хэвийн ажиллагааг хянан ажиллаж байна. | 100% |
| 1.1.20 Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний газарзүйн зураглал боловсруулах | Улсын төсөв | 1. Гоц халдварт өвчний газарзүйн зураглалын тоо | 1. 7<br>2. 6 | 1.6<br>2.6 | Удирдлага болон шинжлэгч эмчийн хүсэлтээр 9 удаагийн хүсэлтээр нийт 12 тооны газарзүйн зураг хийж гүйцэтгэв. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2. Халдварт өвчний зураглалын тоо | | | | |
| 1.1.21 Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийн, нэгтгэх | Улсын төсөв | 1. Хүнсний аюулгүй байдлын тоо мэдээнд хийсэн дүн шинжилгээ тоо<br>2. 21 аймаг, нийслэлийн лабораторийн тоо мэдээнд дүн шинжилгээ хийсэн тоо | 1.3<br>2.1 | 1.5<br>2.1 | Тайлант хугацаанд шаардлагатай тухай бүр датанд дүн шинжилгээ хийж, үг дүнг нэгтгэж тайлагнав. Үүнд:<br>-УМЭАЦТЛ-д 2022-2024 онд БНХАУ- д экспортлох зорилгоор шинжилгээнд хамруулсан адууны мах, чанасан махны дээжийн тоо болон шинжилгээний дүнг нэгтгэж танилцуулав.<br>-Улсын их хурлын гишүүнээс ирүүлсэн албан бичгийн дагуу тус лабораторийн хүнсний шинжилгээний сүүлийн 5-н жилийн датаг нэгтгэсэн тайлан боловсруулж, хүргүүлсэн.<br>-2024 онд хүнд металын шинжилгээнд хүлээн авсан сорьцын тоо, үзүүлэлтийн тоог 7 хоног, сар,жилээр гаргаж танилцуулав.<br>- УМЭАЦТЛ, 21 аймаг,нийслэлийн лабораторийн шинжилгээний мэдээллийг нэгтгэсэн.<br>Тус лабораторид 2022-2025 онд импортын зорилгоор шинжилсэн тахиа, гахайн мах, махан бүтээгдэхүүний дээжийн тоо, эх материалын хэмжээг нэгтгэн боловсруулж хүргүүлсэн. | 100% |

# ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь (%) |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 2.1 Байгууллагын нээлттэй байдлыг хангах.<br>Дэд зорилт. Мал эмнэлгийн эрүүл ахуй, баталгаажуулалт | | | | | | |
| 2.1.1 Дээд шатны байгууллага болон иргэд, аж ахуйн нэгжид лабораторийн шинжилгээний болон бусад үйл ажиллагааны мэдээллийг мэдээллэх | - | 1. Байгууллагын үйл ажиллагааны долоо хоног болон тархварзүйн мэдээний тоо.<br>2. Байгууллагын вебсайт **http://scvl.gov.mn/** болон **http://scvl.opengov.mn/- д** мэдээ байршуулах мэдээний тоо | 1.26<br>2.35 | 1.26<br>2.41 | Лабораторийн үйл ажиллагааны долоо хоног тутмын дотоод мэдээг 26 удаа,<br>Мал, амьтны халдварт өвчний тархварзүйн долоо хоног тутмын мэдээг 26 удаа тус тус боловсруулан МЭЕГ-т тухай бүр хүргүүлсэн. Байгууллагын вебсайт **http://scvl.gov.mn/** болон http://scvl.opengov.mn/- д нийт 13 удаа; фэйсбүүк хуудсанд нийт 83 удаа үйл явдал, мэдээ, мэдээлэл, ажлын байрны зар, баяр ёслолын мэндчилгээ байршуулсан байна. | 100% |
| 2.1.2 Иргэн, аж ахуй нэгж, байгууллага, үйлчлүүлэгчид лабораторийн үйл ажиллагааг шуурхай хүргэх | - | Хариуг хугцаанд нь хүргүүлсэн хувь | 90 | 95 | 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2628 удаагийн хандалтаар 9495 сорьцыг 350 гаруй үйлчлүүлэгчээс (иргэн, аж ахуйн нэгж, орон нутгийн мал эмнэлгийн газар гэх мэт) хүлээн авч шинжилгээг гүйцэтгэсэн байна. Нийт 2475 удаагийн дүнгийн хуудсыг үйлчлүүлэгчид гаргаж өгсөн байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2628 удаагийн хандалтаар 9495 дээжийг 350 гаруй үйлчлүүлэгчээс (иргэн, аж ахуйн нэгж, орон нутгийн мал эмнэлгийн газар гэх мэт) хүлээн авч шинжилгээг гүйцэтгэсэн байна. Нийт 2475 | 95% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удаагийн дүнгийн хуудсыг үйлчлүүлэгчид гаргаж өгсөн байна. Гүйцтэглийн хувь цаг 95%. Харин 37 удаагийн дүнгийн хуудас үйлчлүүлэгчид олгогдоогүй байгаа учир нь хүнд металлын багаж эвдэрсэнтэй холбогдож байна. | |
| 2.1.3. Лабораторийн үйл ажиллагааны тайлан | - | 1. Тасаг, нэгжийн тайлангийн тоо<br>2. Байгууллагын тайлангийн тоо | 1.1<br>2.1 | 1.1<br>2.1 | 7 тасаг нэгжийн тайланг улирал, хагас жилээр гаргаж УМЭАЦТЛ-ийн удирдлагад, байгууллагын хагас жилийн тайланг боловсруулан МЭЕГ-т хүргүүлсэн. | 100% |
| 2.1.4 ILAC MRA гэрээний сунгалт ба итгэмжлэлийн баримт бичгийн бүрдүүлэлт | - | Олон улсын харилцан хүлээн зөвшөөрөл (ILAC MRA)-ын гэрээг шинэчлэн батлуулсан тоо | 1.1 | 1.1 | ILAC MRA гэрээг шинэчлэн батлуулсан, дээр нь өргөдлийн маягтад шаардлагатай материалуудыг боловсруулан Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлж, сунгалт хийлгэж ажилласан. | 100% |
| 2.1.5 Дотоодын ур чадварын сорил (журмын 3.7) | - | Лаборатори хоорондын ур чадварын сорилд оролцсон тоо | 1.2 | 1.1 | ХАБҮЛЛ-ээс зохион байгуулдаг ур чадварын сорилд орох саналыг өгч, хүнсний нян судлал, мөөгөнцөр судлал болон оношилгооны нян судлалын чиглэлээр сорилыг чиглэлээр, сорилыгн гүйцэтгж 100%-ийн үр дүнтэй хамрагдсан.<br>Жилд 2 удаа ур чадварын сорилд оролцдог бөгөөд 2-р ээжийн тест 4-р улиралд ирнэ. | 100% |
| 2.1.6 Байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах | Үйл ажиллагааны зардлаар | 1. Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнээлгээ Байгууллагын гамшгаас хамгаалах төвөлвлөгөөг шинчлэн боловсруулах | 1.1<br>2.1 | 1.1<br>2.1 | Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, бусад холбогдох бичиг баримтыг боловсруулах болон команд штабын сургуулилтын үйл ажиллагаанд бүх ажилтан идэвхтэй оролцов. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1.7 Мэрэгч устгал болон халдваргүйтгэл зохион байгуулах | Улсын төсөв | Мэрэгч устгал, халдваргүйтгэлийн гүйцэтгэл | 1.0 | 1. Бүх талбайд хийсэн | Байгууллагын сорьц хүлээн авах үйлчлүүлэгдчийн хэсэг, лаборатори болон офиссын 1 давхар, B1 давхрын хэсгүүдэд хулганы хор тавьж мэрэгч устгал, ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэв. | 100% |
| 2.1.8 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабоаротариудын эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангах | - | 1. Цахим сургалтын тоо<br>2. Лабораторийн систем болон тандалтын системийг ашиглахад нийтлэг гардаг асуудлыг шийдвэрлэх, тоо | 1.1<br>2.65 | 1.2<br>2.61 | Сүлжээ лабораторийн эмч нарыг арга зүйгээр хангах ажлын хүрээнд 2 удаа (Дуудлагын үед тархвар зүйн судалгаа хийх, бэлтгэл хангах”,“Тархвар зүйн мэдээлэл боловсруулах тухай) тархвар зүйн цахим хичээл бэлтгэн танилцуулсан, Мөн лабораторийн систем болон тандалтын системийг ашиглахад нийтлэг гардаг асуудлыг шийдвэрлэхээр 61 удаагийн тохируулга хийн, заавар өгч ажиллаа. | 100% |

# ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь (%) |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 3.1 Салбарын хэмжээнд хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд зөрчлийг шалган шийдвэрлэх, хэрэгжилтийн хангуулах<br>Дэд зорилт. Мал эмнэлгийн хяналт | | | | | | |
| 3.1.1 Гүйцэтгэсэн дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ | - | Залруулсан үл тохирол, хувь | 1.0 | 1.1 | Лабораторийн үйл ажиллагаа, техникийн чадавхыг ISO17025-д нийцүүлж, дотоод аудитыг төлөвлөгөөний дагуу хамрагдаж, гарсан сайжруулах төлөвлөгөөний залруулах тайланг заасан хугацаанд тайлагнаж, залруулав. | 100% |
| 3.1.2 Гүйцэтгэсэн дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээний хяналт | - | 1. Дотоод аудитын хяналт шалгалт, тайлан боловсруулах Удирдлагын дүн жинжилгээний хяналт, тайлан | 1.1<br>2.1 | 1.1<br>2.0 | Дотоод аудитын чанарын тогтолцооны баримт бичгийн бүртгэл, лабораторийн орчин, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, эрсдэл, дотоод хяналтын төлөвлөгөө, хэрэгжилт зэрэг чиглэлийн хүрээнд 2025 оны 4 дүгээр сарын 24-нөөс 5 дугаар сарын 12-ны өдрийн хугацаанд зохион байгуулсан. Залруулах ажлыг тодорхойлон лабораториудад танилцуулан тэдгээрийн дагуу хийгдсэн ажлын | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайланг хүлээн авч, нэгтгэсэн тайланг боловсруулж хүлээлгэн өгөв.<br><br>Удирдлагын дүн шинжилгээний хяналт тайлан 4-р улиралд бичигдэнэ. | |
| 3.1.3 ISO/IEC 17025:2018 стандартын чанарын хяналтын тогтолцооны хяналт | - | 1. Биоаюулгүйн хяналт, сургалт<br>2. Бүртгэлийн баримт бичиг, журналын хяналт<br>Цацрагийн болон химийн бодисын хяналт | 1.20<br>2.1<br>3.0 | 1.29<br>2.1<br>3.1 | Лабораторийн биоаюулгүйн үйл ажиллагаанд долоо хоногт 1 удаа хяналт хийж, гарсан үл тохирлыг лабораторийн эрхлэгч, хариуцсан мэргэжилтэнд залруулах даалгаврыг хугацаатай өгч ажиллаа. Хяналтын бүртгэл хөтлөх дэвтрийг боловсруулсан.<br>УМЭАЦТЛ-ийн 2025 онд шаардлагатай бүртгэлийн журналын судалгаа гаргаж шаардлагатай лабораториудад хэвлэж өгсөн. Үүнд: Биоаюултай хог хаягдал устгалын журнал /халдварт, халдваргүй, Элемент ХХК/, устгах дээжийн бүртгэл, экспертизийн дэвтэр - 4 ш, BSL-III зэрэглэлийн лаб-д ээрэг материалын бүртгэл гэх мэт.<br>Цацрагийн үүсгүүрийн ашиглалт болон дотоод хяналтын тайлан боловсруулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны салбарын хяналтын газарт хүргүүлсэн | 100% |

# ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь (%) |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 4.1 Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх<br>Дэд зорилт. Төрийн захиргааны удирдлагын нэгдмэл байдлыг хангах | | | | | | |
| 4.1.1 Байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах; | Улсын төсөв | Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах | 1 | 1 | Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу Захирлын 2025 оны А/01 дугаар тушаалаар албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт орсон ба мэдээллийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим системд байршуулсан. Жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөөг өргөдлийн дагуу олгож, өөрчлөлтийг ХНУМТС-д цаг тухай бүр гүйцэтгэж байна. | 100% |
| | Улсын төсөв | Боловсон хүчний хөдөлгөөн | 95 | 41 | Байгууллагын боловсон хүчинтэй болон үйл ажиллагаатай холбоотой 41 тушаал, Хувь хүн, албан хаагчдаас 29 өргөдөл, хүлээн авч, бүртгэлд хамруулан (шинээр ажилд томилуулах, чөлөө хүсэх, үндсэн ажилтнаар томилуулах, ажил хавсран гүйцэтгэх, хавсран гүйцэтгэсэн албан | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тушаалын цалингийн хувь авах) 10 өргөдлийг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн нийт 27 өргөдлийг шийдвэрлүүлж ажилласан. /1 өргөдлийг эзнийх нь хүсэлтээр буцаав/. | |
| | | | 1 | 1 | Лаборатори, нэгжүүдээс 2025 оны ээлжийн амралтын хуваарийг авч Захирлын 2025 оны Б/01 тушаалаар хуваарийг батлуулж, хуваарийн дагуу 13 эмч, ажилтанд ээлжийн амралтыг олгоод байна. | 100% |
| | Улсын төсөв хагас жил | | 30 | 20 | Эмч, ажилчдын цагийн бүртгэлд хяналт тавьж, шаардлагатай үед өрөө, лабораториудаар явж өглөө, орой давхар бүртгэл хийж ажилласан. Цагийн бүртгэлийн нэгтгэлийг сард 2 удаа гаргаж цалинг олох, сар бүр нэгж, лабораторийн дарга, эрхлэгч нараас ирүүлсэн албан хаагчдын ур чадварын үнэлгээг нэгтгэн, хянаж ажилчдын ур чадварыг олгож байна. | 100% |
| 4.1.2 Байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, | Улсын төсөв хагас жил | | 5 | 3 | Тайлант хугацаанд өөрийн хүсэлтээр 1 албан хаагчийг чөлөөлж, шинээр 2 эмч, ажилтанг ажилд томилсон. | 100% |
| | Улсын төсөв хагас жил | Шагнал, урамшуулал | 18 | 6 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдэврийн яамны 100 жилийн ойг тохиолдуулан ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа хошуучлан ажилласан эмч, ажилчид ахмад эмч, ажилчдыг тодорхойлсноос 1 ахмад эмч Төрийн одон медаль | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| төлөвлөлт, хэрэгжилтийг хангах; | | | | | “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор, 3 эмч Засгийн газрын шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар, 2 эмч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны салбарын “Тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр тус тус шагнагдав. | |
| 4.1.3 Байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах; | Улсын төсөв 57,8 сая төгрөг | Нийгмийн баталгаа | 0 | 1 | Мал эмнэлгийн Ерөнхий газарт 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 27 тоот албан бичгээр тус лабораторийн “албан хаагчдын унаа, хоолны мөнгө” 2025 оны 02 дугаар сарын байдлаар 18,000.0 төгрөг олгож байныг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт, инфляцын өөрчлөлттэй уялдуулан албан хаагчдынхаа аху амьдрал, нийгмийн асуудлыг дэмжих зорилгоор 2025 оны 05 дугаар сараас эхлэн унаа, хоолны мөнгийн 28,000.0 төгрөг болж хагас жилийн байдлаар 57.8 сая төгрөг олгосон байна. | 100% |
| | Улсын төсөв хагас жил | | 0 | 1 | Нийслэл, 21 аймгийн Мал эмнэлгийн лабораторийн эмч, ажилчдын цалин, албан тушаалын зэрэглэл өөрчлөгдөж ТҮ-ээс ТҮМ рүү шилжсэнээр буурсан, өссөн өөрчлөлтийн талаарх судалгаа, хортой нөхцлийн нэмэгдэл, орон нутгийн нэмэгдлийн талаарх санал, хүсэлтийг албан бичгээр ХХААХҮЯ-д УМЭАЦТЛ-ийн 2025.05.27-ны өдрийн 57 дугаартай албан бичгээр, МЭЕГ-ын ТЗУГ-т | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025.05.27-ны өдрийн 58 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. | |
| | Улсын төсөв хагас жил | Нийслэл, 21 аймгийн Мал эмнэлгийн лабораторийн эмч, ажилчдын цалингийн өөрчлөлт, хортой нөхцлийн нэмэгдэл, орон нутгийн нэмэгдлийн талаар | 0 | 1 | Нийслэл, 21 аймгийн Мал эмнэлгийн лабораторийн эмч, ажилчдын цалин, албан тушаалын зэрэглэл өөрчлөгдөж ТҮ-ээс ТҮМ рүү шилжсэнээр буурсан, өссөн өөрчлөлтийн талаарх судалгаа, хортой нөхцлийн нэмэгдэл, орон нутгийн нэмэгдлийн талаарх санал, хүсэлтийг албан бичгээр ХХААХҮЯ-д УМЭАЦТЛ-ийн 2025.05.27-ны өдрийн 57 дугаартай албан бичгээр, МЭЕГ-ын ТЗУГ-т 2025.05.27-ны өдрийн 58 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. | 100% |
| 4.1.4 Байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах; | Улсын төсөв 3.7 сая төгрөг | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,Авилгын эсрэг хуулийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх | 10 | 10 | Санхүү, аж ахуй, үйлчилгээний нэгжийн даргаар томилогдсон Б.Цэрэндаваагийн ХАСУМ-ын мэдээллийг АТГ-т хүргүүлсэн ба ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тул 02-р сарын 20-ны өдрөөс албан тушаалд томилсон.<br><br>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу лабораторийн ХАСХОМ мэдүүлэх 10 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан авч https://meduuleg.iaac.mn сайтанд баталгаажуулсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.5 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль | Улсын төсөв хагас жил | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн албаны зохион байгуулалт” улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Архивын ерөнхий газрын даргын 2024 оны А/91 дүгээр тушаалаар баталсан “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай” тушаал, холбогдох дүрэм, журмыг судлан байгууллагын 2025 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулах, батлуулах | 1 | 1 | Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай” тушаал, холбогдох дүрэм, журмыг судлан байгууллагын 2025 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж батлуулсан. | 100% |
| | Улсын төсөв 5.0 сая төгрөг | | 1 | 3 | Байгууллагын архивын өрөөг 1 давхарт хууль, стандартын дагуу тохижуулахаар зориулалтын тавиур, шүүгээр байршуулсан. Шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийг авах, улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулахаар Захирлын 2025.02.27.-ны өдрийн А12 тоот тушаалаар ажлын хэсэг, ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Байгууллагын 2025 оны ХХНЖ-ыг боловсруулан батлуулсан. | 80% |
| 4.1.6 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль | Улсын төсөв хагас жил | Байгууллагын байнга хадгалагдах хадгламжийн нэгжийг цахимжуулах | 0 | 1 | Байгууллагын 2019-2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны чиглэлээр болон боловсон хүчний чиглэлээр гаргасан тушаалуудыг скайнердан цахимжуулан, Hard дискэнд хадгалж цахим архив үүсгэсэн. | 100% |
| | | | 0 | 1 | Байнга хадгалагдах баримтыг цахимжуулах ажлын хүрээнд 2018-2024 оны тандалтын тайлангуудыг холбогдох эмч, ажилтнуудад чиглэл өгч скайнердуулж, цахимжуулсан. Байгууллагын архивын ажилтны эрсдлийн төлөвлөгөө, архивын ажлын эрсдлийн төлөвлөгөөг 2025 оны 01 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгээр сарын 06-ны өдөр боловсруулж батлуулав. | |
| | Улсын төсөв 0,9 сая төгрөг | | 0 | 1 | Байгууллагын архивын нийтлэг журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд архивын 6 төрлийн тэмдгийг 900,000 (есөн зуун мянга) төгрөгөөр “Хаан тамга” ХХК-д шинээр хийлгэв. | 100% |
| | Улсын төсөв хагас жил | | 0 | 1 | “Баримт бичгийн стандарт 5140-2021”, “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх” сэдвээр мэргэжлийн байгууллагаас сургалт зохион байгуулсан | 100% |
| 4.1.7 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль | Улсын төсөв хагас жил | Нэгж, лабораторийн албан хаагчдаас архивт баримтыг стандартын дагуу хүлээн авах, түүний чанарт хяналт тавих | 18 | 24 | Байгууллагын удирдлага, боловсон хүчинтэй холбоотой 2024 оны архивын баримтыг эмхлэх, хуудас дугаарлах, хавтаслах, жинлэх, хүлээн авсан тухай анхан шатны бүртгэл хөтлөх зэрэг ажлыг бие даан 24 хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн. | 100% |
| | | | 1 | 1 | 2024 оны Захирлын А/тушаал-2 боть, А4-явсан бичиг- 2 боть, А5-явсан бичиг - 2 боть, ирсэн бичиг-2 боть, 2025 оны гэрээ 2 боть архивт бэлтгэн мөн цахим архив үүсгэв. | 100% |
| | | | 40 | 68 | 2024 оны архивын баримтыг хүлээн авах ажлын хүрээнд нэгж, лабораторийн эмч, ажилчдад архивын баримтын хуудсыг дугаарлах, архивын баримтыг цэгцлэх, хавтаслах талаар 20 эмч, ажилтанд зөвлөгөө өгч, архивын анхан шатны бүртгэлүүдийг холбогдох мэргэжилтнүүдэд цахимаар хүргүүлж ажилласан. Мөн байгууллагын архивт | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нөхөн бүрдүүлэлт хийх, архивт баримт хүлээн авах хуваарийг батлуулан нэгж, лабораторийн дарга/эрхлэгч нарт хүргүүлэн ажилласнаар нэгж, лабораториудаас 22 хадгаламжийн нэгж хүлээн авч, байгууллагын архивт 46 хадгаламжийн нэгж хүлээн авч, нөхөн бүрдүүлэлт хийсэн. | |
| 4.1.8 Албан бичиг хөтлөлтийн нийтлэг журам | Улсын төсөв хагас жил | Баримт бичгийн стандарт, албан хэрэг хөтлөх журмыг мөрдөх, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг эрхлэх, анхан шатны бүртгэлийг хөтлөх, тайлагнах, тамга тэмдэг, баталгааны хэвлэмэл хуудсыг зориулалтаар нь ашиглах | 368 | 337 | Эхний хагас жилийн байдлаар харилцагч байгууллагуудаас 63 албан бичиг хүлээн авч бүртгэн захиралд танилцуулсны дагуу холбогдох эмч, ажилтнуудад хүргүүлж нийт 54 албан бичиг шийдвэрлэгдсэн.. Мөн А4 албан бичиг-59, А5 албан бичиг-69 харилцагч байгууллагуудад явуулсан байна. Захирлын 53 А/тушаал, Б/31 тушаал баталгаажиж гарсан ба орон нутагт ажиллах 39 хүний томилолтын хуудсыг гаргаж өгсөн. | 100% |
| | | | 0 | 1 | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Захиралын зөвлөлийн хурлаар танилцуулж, нэгж, лабораториудаас саналыг авч нэгтгэн боловсруулж дууссан. | 100% |
| | | | 0 | 1 | Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ОУ-ын байгууллагаас 2024-2025 онд тус лабораторийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцсон хүмүүс, лабораторийн удирдлага, эмч, ажилчдын 2024-2024 онд гадаад улс оронд хурал, зөвлөгөөн, сургалтанд оролцсон талаарх судалгааг УМЭАЦТЛ- | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ийн Захиралын 2025.05.02-ны өдрийн 54 тоот албан бичиг, 2025.05.07-ны өдрийн 57 тоот албан бичгээс тус тус МЭЕГ-т хүргүүлж ажилласан. | |
| 4.1.9 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, биелэлтэд хяналт тавих, нэгдсэн удирдлагаар хангах, нэгтгэн боловсруулж тайлагнах; | | Төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалд нийцүүлэн боловсруулсан эсэх; | 1 | 1 | Төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалд нийцүүлэн боловсруулж, 2025 оны 1 дүгээр сард МЭЕГ-т хүргүүлсэн. | 100% |
| 4.1.10 Лабораторийн төсвийн хүрээний мэдэгдэл, болон төсвийн төслийг боловсруулан дээд шатны байгууллагад хугацаанд хүргүүлэх | Төсвийн саналын нэгтгэлээр | Төвлөрүүлэн захирагчийн хүрээнд үйл ажиллагааны болон мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулалтын ирүүлсэн саналыг хянан нэгтгэн боловсруулж дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх | 1.0 | 1.0 | Эхний хагас жилд: 2024 онд Төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн төслийн саналыг хянан нэгтгэж хугацаанд нь ХХААХҮЯаманд хүргүүлсэн Салбарын төсвийн хүрээний мэдэгдлийг нэгтгэн боловсруулж ХХААХҮЯамд хүргүүлэх 6 сард багтаан харьяа байгууллагууд 2026 оны төсвийн төсөөлөл ирүүлэх чиглэлийг хүргүүлж арга зүйгээр хангах | 100% |
| 4.1.11 Лабораторийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг сар бүр хуулийн хугацаанд үнэн | Төсвийн саналын нэгтгэлээр | Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон Санхүүгийн нэгдсэн тайланг үнэн зөв хуулийн хугацаанд гаргаж тайлагнах | 6 | 6 | 2024 оны санхүүгийн тайлан нэгтгэн боловсруулж хуулийн хугацаанд иж бүрэн бэлтгэн гаргаж Аудитын байгууллагад хүргүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр ХХААХҮЯ-нд 6 удаа хүргүүлсэн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| зөв гаргаж, санхүүгийн тайланг иж бүрэн гаргаж, хуулийн хугацаанд аудитын байгууллагаар хянуулах Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх | | | | | | |
| 4.1.12 Мал,амьтны гоц халдварт, халдварт өвчний үед био-аюулгүй байдал болон бэлэн байдлыг хангаж ажиллах | Улсын төсөв | BSL-III зэрэглэлийн болон хөдөлгөөнт лабораторийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллах | 2 | 3 | Дэлхийн банкны санхүүжилтын хүрээнд ЭНЛАЙТ ХХК нь BSL-III лабораторийн агааржуулалтын ситемийг автомат удирдлагын системд холбосон, урсгал засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж ажиллаж байна.<br><br>Био-аюлгүйн 3-р зэрэглэлийн лабораторит шинээр -$80^0$c босоо гүн хөлдөөгч суулгаж ашиглалтад оруулсан.<br><br>Хөдөлгөөнт лабораторит давхар гоц халдварт өвчний шинжилгээг хийх нөхцлийг хангаж ажилласан. Мөн УМЭАЦТЛ-ийн ерөнхий инженер А.Болдбаатар, био-аюулгүйн лабораторийн инженер, техникч Л.Бадамдорж, цахилгааны сантехникийн инженер Ш.Батнасан нарыг BSL-II лабораторийг ажиллуулах, хэвийн үйл ажиллагааг хангах, сөрөг даралтыг шалгах, сүлжээний програмыг ашиглах талаар сургалтад хамруулсан. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.13 Мал,амьтны гоц халдварт, халдварт өвчний үед био-аюулгүй байдал болон бэлэн байдлыг хангаж ажиллах | | Хөдөлгөөнт лабораторийн бэлэн байдлыг хангаж ажиллах | 3 | 4 | BSL III лабораторийн халуун усны 2 ширхэг насос шатсаныг шинээр сольж тохируулга хийж хэвийн ажиллагаанд оруулсан.<br><br>BSL III лабораторийн халуун усны шугамын хэвийн ажиллагааг хангах зорилгоор монтажыг өөрчилж хуванцар хоолойг зэс хоолойгоор сольж гагнасан.<br><br>Хөдөлгөөнт лабораторид орж ажиллах тухай бүр агааржуулалтын ситемийн хэвийн үйл ажиллагаа, хяналтын параметруудад хяналт тавин ажилласан. Лабораторийн аюулгүй байдлын ажиллагаанд лабораторийн ерөнхий инженер А.Болдбаатар, био-аюулгүйн ажиллагаа, чанарын менежер П.Дулам нар хяналт тавин ажиллаж байна. Ямар нэгэн техникийн доголдолгүй хэвийн үйл ажиллгааа явагдаж байна.<br><br>Лабораторын бохирын сав дүүрсэнийг ариутгаж, бохирын машинаар соруулсан.<br>Хөдөлгөөнт лабораторын 2 ширхэг hepa шүүлтүүрийг графикт хугацаанд нь сольсон, аккумлятор, масло, маслын шүүр зэргийг шинээр сольж тохируулга хийж дотор болон гаднаас удирдаж асааж хэвийн найдвартай ажиллагааг хангаж, асааж хөдөлгөөнд бэлэн болгосон | 100% |
| 4.1.14 УМЭАЦТЛ-ийн | | Лабораторийн хэмжээнд ашиглагдаж байгаа тоног | 63 | 20 | Лабораторийн тоног төхөөрөмжийн засварыг сар бүрээр хувиарын дагуу | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| хэмжээнд ажиллаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах | Улсын төсөв хагас жил | төхөөрөмж, багаж хэрэгсэлд урсгал засвар үйлчилгээг төлөвлөж ажиллах, бэлэн байдлыг хангаж ажиллах | | | тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллахын тулд 7 хоногт 1 удаа лаборатори бүрээр явж, үзлэг хийж, хагас жилийн хугацаанд 3 лабораторийн (ГХӨОТЛ, ХПӨОТЛ, ХЭАҮШЛ) нийт 20 тоног төхөөрөмжийн гэмтэл, доголдлыг арилгаж, шаардлагатай сэлбэг хэрэгслийг захиалж, угсарч хэвийн ажиллагаанд оруулан ажиллаж байна.<br><br>Тоног төхөөрөмжийн техникийн бичиг баримтыг бүрдүүлэх, бүртгэлийг сайжруулах, тогтмолжуулах зэрэг ажлуудыг хийсэн. | |
| | | | 12 | 14 | Тайлант хугацаанд дараах байдлаар бэлэн байдлыг хангаж ажиллав. Үүнд:<br>➢ Хоёр эйркондиционер ХЭАҮШЛ-т шинээр суурилуулж ашиглалтанд оруулсан.<br>➢ Үлдэгдлийн лабораторид ионжуулагч усны аппаратын шүүлтүүрийг сольж ионжуулсан ус ашиглах боломжтой болгосон.<br>➢ Цахилгаан автоклав 1 ширхэг, термостат 3 ширхэг худалдан авч тохируулан хэвийн ажиллагааг хангасан.<br><br>Байгаль орчны лабораторийн 3 гаралттай холигч хугарсан учраас шинээр захиалж, суурилуулсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.15 УМЭАЦТЛ-ийн хэмжээнд ажиллаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах | Улсын төсөв хагас жил | Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний бүртгэл, нэгдсэн бүртгэл, Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүртгэл, шингэн азотын хяналтын бүртгэл, Хөдөлгөөнт лабораторийн ашиглалт, засвар үйлчилгээний бүртгэсэн байх | 8 | 10 | Лабораторийн хэмжээнд ашиглаж байгаа хийн баллоны судалгаа гаргаж, техникийн бичиг баримтыг бүрдүүлэх, бүртгэлийг сайжруулах ажлуудыг хийсэн.<br>Азотын (Аргон, Азот, Нүүрсхүчил) шингэн, хийн баллоныг тухай бүрт нь захиалан авч угсралт тохируулга хийж, эмч нарын ажиллах нөхцлийг тасалдалгүй хангаж ажиллалаа.<br>Хийн шланк, муфть, тройник редукторын алдагдлыг илрүүлж тухай бүрт нь засварлаж хэвийн болгосон | 100% |
| 4.1.16 Санхүү, төсвийн захиран зарцуулалт | Улсын төсөв хагас жил | 2024 оны эд хөрөнгийн тооллогын комисс томилуулан хагас, бүтэн жилийн тооллого явуулах, ашиглагдахгүй болсон, техник эд хогшлыг ТӨХ болон байгууллагын техник, үнийн комиссын шийдвэрийг үндэслэн засварлан ашиглах, актлах, устгах | 1 | 1 | ТӨБЗГ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 22 өдрийн 45 дугаар тогтоол “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай”, ӨХБЗ-ийн 2025/01 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн балансын дансанд бүртгэлтэй 180.4 сая төгрөгний үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан. Мөн ТӨБЗГ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 22 өдрийн 36 дугаар тогтоолын дагуу “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 967.1 сая төгрөгний үндсэн хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн бүртгэж авсан. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн биелэлтийг ТӨБЗГ-т 2025 оны 03 дугаар сарын 21 өдрийн 35 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан. | 100% |
| | | | 1 | 1 | **Үндсэн үйл ажиллагааны санхүүжилт:**<br>Үндсэн үйл ажиллагааны орлого | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.17 Санхүү, төсвийн захиран зарцуулалт | Улсын төсөв хагас жил | Төрийн сантай харилцаж байгууллагын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээ хийх, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, НДШ-ийн тайлан боловсруулж хянуулах, сар бүр шинжилгээний орлогын тооцооны тулгалт хийж бүртгэх | | | (лабораторийн дээж шинжилгээний төлбөртэй хураамж) 276.3 сая төгрөг төвлөрүүлж ажиллахаас 194.5 сая төгрөг төвлөрүүлж 81.8 сая төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны орлого тасарч байна. Улсын төсвөөс 842.4 сая төгрөгийн санхүүжилт авч байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. Үүнд: Цалин хөдөлмөрийн хөлсөнд 355,4 сая төгрөг, АО-с нийгмийн даатгалын шимтгэлд 83,3 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 71,3 сая төгрөг, хангамж бараа материалын материал 10,0 сая төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэл 2,6 сая төгрөг, багаж техник хэрэгсэл 28,2 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 19,9 сая төгрөг, урсгал засварын зардал 35,2 сая төгрөг, дотоод албан томилолт 3,5 сая төгрөг, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх 48,7 сая төгрөг, малын гоц халдварт өвчний тандалт судалгаа 32,6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 3.1 сая төгрөг, харуул хамгаалалтын зардал 1,0 сая төгрөг, ажил олгогчоос нэг удаа олгох тэтгэмж урамшуулал зардалд 0,4 сая төгрөгийг тус тус зарцуулж байгууллагын үндсэн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажилласан. 2025 оны 05-р сард сангийн яамнаас 12,3 сая төгрөгийг (үндсэн үйл ажиллагааны зардлаас 11.4 сая төгрөг, харуул | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.18 Санхүү, төсвийн захиран зарцуулалт | Улсын төсөв хагас жил | Төрийн сантай харилцаж байгууллагын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээ хийх, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, НДШ-ийн тайлан боловсруулж хянуулах, сар бүр шинжилгээний орлогын тооцооны тулгалт хийж бүртгэх | | | хамгаалалтын зардлаас 0.2 сая төгрөг, ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал зардлаас 0.5 сая төгрөг, мал, амьтан эрүүлжүүлэх зардлаас 0.1 сая төгрөг) буцаан татан төвлөрүүлсэн нь цаашид байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахад хүндрэл үүсч байна.<br><br>Хагас жилийн онцлох ажил, үйлчилгээг дурдвал:<br><br>1. 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар **өөрчлөлтгүй дүгнэлтийг** 2025 оны 02 дугаар сарын 25 өдрийн 07/822 дугаартай гэрчилгээг хүлээн авсан<br>2. Команд штабын сургалтын бэлэн байдлын хангахаар 2025 оны 02 дугаар сарын 27 өдрийн Захирлын А/11 тушаалаар батлагдсан хавсаралтын дагуу бүх албан хаагчдыг ажлын хувцас (аранз, гутал, өмд, цамц, подволк, малгай), богино долгионы холбоо барих станц, хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, бичиг хэргийн материал, бусад хангамж, бараа материалаар хурдан шуурхай хангаж ажилласан байна | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.19 Санхүү, төсвийн захиран зарцуулалт | Улсын төсөв хагас жил | Төрийн сантай харилцаж байгууллагын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээ хийх, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, НДШ-ийн тайлан боловсруулж хянуулах, сар бүр шинжилгээний орлогын тооцооны тулгалт хийж бүртгэх | 1 | 1 | **Нэмэлт санхүүжилт:**<br><br>Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн төрийн сангийн харилцах дансанд 212.4 сая төгрөгний орлого төвлөрсөн. Үүнд:<br><br>1.Сангийн яамнаас татаас санхүүжилтийн авлага:<br><br>➢ Австри улсын олон улсын атомын энергийн агентлагтай хамтарсан “Шинэ болон дахин сэргэж буй зооноз өвчин” хамтын төслийн үлдэгдэл санхүүжилт 72.5 сая төгрөг;<br>➢ БНСУ-ын Амьтан ургамлын хорио цээрийн газартай хамтарсан “Монгол улсад эргэлдэж байгаа шүлхийн вирусын генетикийн шинжилгээний ба судалгаа” хамтын төслийн 2024 оны үлдэгдэл санхүүжилт 37.7 сая төгрөг нийт 110.2 сая төгрөгний татаас санхүүжилтийг буцаан авсан.<br><br>2.Олон улсын хэргжиж буй төсөл хөтөлбөр: | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ➢ БНСУ-ын Амьтан ургамлын хорио цээрийн газартай хамтарсан “Монгол улсад эргэлдэж байгаа шүлхийн вирусын генетикийн шинжилгээний ба судалгаа” хамтын төсөл 97.2 сая төгрөг санхүүжилтийг хүлээн авсан.<br><br>3.Мал эмнэлгийн ерөнхий газар:<br>Команд штабын сургалтын бэлэн байдлыг хангаж ажиллахад 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосныг зориулалтын дагуу зарцуулж ажиллалаа. | |
| 4.1.20 Санхүү, төсвийн захиран зарцуулалт | Улсын төсөв хагас жил | 2026 оны төсвийн төсөл боловсруулан Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ХХААХҮЯ-нд хүргүүлэх. | 1 | 1 | 2026 оны төсвийн төслийг боловсруулж, хуулийн хугацаанд МЭЕГ-т хүргүүлсэн. | 100% |
| | | Сар, улирал, жилийн санхүүгийн тайлан | 4 | 4 | Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, нийгмийн даатгалын тайлан, албан хаагчдын цалин, хөлснөөс суутгасан орлогын албан татварын тайлан, шилэн дансны мэдээг цаг хугацаанд нь мэдээлсэн, мөн төрийн өмчийн тооллогын системд (umch.sgov.mn) тухай бүр нь тайлагнаж харъяалах дээд шатны төрийн захиргааны байгууллагын цахим системд тайлагнаж баталгажуулсан. Монгол улсын үндсэн хууль, төсвийн тухай хууль, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.21 Санхүү, төсвийн захиран зарцуулалт | Улсын төсөв хагас жил | балансыг цаг хугацаанд нь гаргаж, үр дүнг тухайн жилийн төсөвтэй уялдуулан ХХААХҮЯ, СЯ, Төрийн санд тайлагнах, аудитын хяналт шалгалтанд үнэн зөв мэдээллээр хангах, Шилэн дансны тайлан мэдээ тухай бүр нь тайлагнаж мэдээллэх, судалгаа | | | нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн дагуу шилэн дансны мэдээллийг тухай бүр хэтэлж ил тодоор тайлагнасан.<br><br>2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өөрчлөлтгүй дүгнэлтийг 2025 оны 02 дугаар сарын 25 өдрийн 07/822 дугаартай гэрчилгээг хүлээн авсан.<br><br>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулага нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд ил тод байршуулбал зохих нийт 81 мэдээллээс 81 мэдээлэл мэдээлж 2 мэдээллийг хугацаа хоцрооч байршуулсан. Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар байгууллага дотооддоо гүйцэтгэлийн хяналтыг сар бүр хийж хэрэгжүүлж байна.<br><br>2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 925.0 сая төгрөгөөр боловсруулж, батлуулсан. | |
| 4.1.22 Санхүү, төсвийн захиран зарцуулалт | Улсын төсөв хагас жил | Сар, улирал, жилийн санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд нь гаргаж, үр дүнг тухайн жилийн төсөвтэй уялдуулан ХХААХҮЯ, СЯ, Төрийн санд тайлагнах, аудитын хяналт | 0 | 1 | Байгууллагын 2020-2025 онуудын төсвийн орлого /Улсын төсвийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого/, төсвийн зарлагыг өсөж буурсан шалгаан, зардлын бүтцээр нь шинжилгээ хийж 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Захиралын зөвлөлийн хурлаар танилцуулсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | шалгалтанд үнэн зөв мэдээллээр хангах, Шилэн дансны тайлан мэдээ тухай бүр нь тайлагнаж мэдээллэх, судалгаа | | | | |
| 4.1.23 Засвар, цэвэрлэгээ, тохижилт, ногоон байгууламж | Улсын төсөв хагас жил | Лабораторийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл байдлыг хангах, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах | 70 | 78 | 2025 оны хагас жилийн байдлаар лабораториудад галын аюултай байгаа их эрсдэлтэй хуучирч муудсан цахилгаан гэрэлтүүлэг 32 ширхэг, разетка ил далд 20 ширхэг, уртасгагч 10 ширхэг, уртасгагч толгой 10 ширхэг, унтраалга 6 ширхэгийг захиалга авч, шинээр тус тус суурилуулж ажилчдын хэвийн ажиллаж нөхцлөөр ханган ажиллалаа. | 100% |
| | | | 0 | 1 | Лабораторийн барилгын гаднах гэрлэн хаяг 2017 онд хийгдсэнээс хойш байгууллагын хаяг огт шинэчлэгдээгүй, ихэнх үсэг асахгүй болсон тул Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр III-ын дагуу байгууллагын гаднах гэрлэн хаягийг хос бичгээр тод, томруулан, орчин үеийн шинэ загварт нийцүүлж 2025 оны 05 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд байгууллагын гаднах гэрлэн хаягийг (крилл, монгол үсэг) бичгээр хийлгэсэн. | 100% |
| | | | 1 | 1 | 2025 оны 01 дүгээр сард хурлын заалны тоног төхөөрөмж, ширээ сандлуудыг зөөж хураан, 1, 2, 3-н давхарын коридорт халаагуур, суурьлуулж, хурлын заал болон гадна үүдний шатнуудад дрож зүсэж нааж, байгууллагын халаалтын дулааныг шалгаж өвөлжилтийн бэлэн байдлыг хангаж ажилласан. | 100% |
| | Улсын төсөв хагас жил | | 0 | 1 | А болкны шатны доод хэсгээс гаднаас салхи орж байгаа хэсгүүдийг шалгаж хөөс, хөөсөнцөрдөж дуулга хийсэн. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.24 Засвар, цэвэрлэгээ, тохижилт, ногоон байгууламж | | | 0 | 1 | BSL III лабораторын төхөөрөмжийн техникийн өрөөний гэрэлтүүлгийг шинэчлэв. | 100% |
| | Улсын төсөв 0,9 сая төгрөг | | 0 | 1 | Улсын бүртгэлийн 0732 УБЕ дугаартай фургон автомашины кроп тайлж, ган диска, пирда диска, муфьт шарик солив. Мөн барбан зүрх арааны сальник, чагтан голын шарикийг 0,9 сая төгрөгний сэлбэг хэрэгсэл, худалдан авч сольж засвар үйлчилгээг хийсэн. | 100% |
| | Улсын төсөв хагас жил | | 1 | 1 | Угаалгын машин бүрэн автомат, төв офиссын узелийн өрөөний халаалтын дулаан дамжуулагч насос, ариун цэврийн өрөөнүүдийн суултуурын уян хоолой, гармон сальник, почкины ком, угаалтуурын холигчууд, худалдан авч тухай бүрт нь сольж засварлан хэвийн үйл ажиллагаанд оруулсан. | 100% |
| 4.1.25 Засвар, цэвэрлэгээ, тохижилт, ногоон байгууламж | Улсын төсөв хагас жил | | 10 | 13 | Цэвэр усны холигч 16 ширхэг, уян хоолой 7 ширхэг, почкины ком 7 ширхэг гармон сальник 4 ширхэг тус тус сольсон. Бохирын бөглөөс 13 удаа гаргасан. | 100% |
| | | | 5 | 6 | Цэвэр усны насос 2 ширхэг, халуун усны насос 2 ширхэг, өргөлтийн насос 1 ширхэг, сүлжээний эргэлтийн насос 1 ширхэг тус тус суурилуулав. | 100% |
| | | | 1 | 1 | Цахилгаан автоклав 1 ширхэг, елиза уншигч 1 ширхэг, термостат 1 ширхэг засварлаж тохируулга хийж хэвийн ажилд оруулсан. | 100% |
| | | | 5 | 8 | Байгууллагын коридор шатны хонгил, хаалганд 8 ширхэг дулааны хөшигөн тень суурилуулж дулаан хангамжийг сайжруулсан. | 100% |
| | | | 1 | 1 | Байгууллагын нийтийн эзэмшлийн кордиориуд, 6 ширхэг 00, заалууд, зарим | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өрөөнүүдийн өдөр тутамын цэвэрлэгээ үйлчилгээг хийн ажиллалаа. | |
| | | Лабораторийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл байдлыг хангах, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах | 1 | 1 | Улсын бүртгэлийн 0732 УБЕ дугаартай фургон автомашинаар Архангай аймгийн Өгийнуурнд цэнгэг усны загасны дээж авах, Дорноговь аймгийн Хөвсгөл сум, Улаанбадрах сумдуудад зээрийн сүргийн тандалт, МЭЕГ-ын албан хаагч нартай Орхон аймаг, Булган аймгуудаар 3500 км албан томилолтоор автомашинаар үйлчилгээ үзүүлсэн.<br><br>Төв аймгийн Баянчандмань сумаас тахианы тэжээл авхаар 3 удаа, Төв аймгийн Эрдэнэ суманд 1 удаа, Алтанбулаг суманд 3 удаа хонь, үхэрийн цусны дээж авах эмч нартай 560 км улсын бүртгэлийн 0732 УБЕ дугаартай фургон автомашинаар үйлчилгээнд явсан.<br><br>Гадаадын зочид төлөөлөгч нарыг нисэх онгоцны буудлаас тосож, буудалд байрлуулах, нисэх онгоцны буудал руу хүргэж өгөх, Гамшигаас хамгаалах сургуулалтын үйл ажиллагааны үйлчилгээнд, Биокомбинат, хот дотор тухай бүрд нь эмч нарт үйлчилгээнд 2100 км улсын бүртгэлийн 0732 УБЕ дугаартай фургон автомашинаар үйлчилгээнд явсан.<br>Дархан-Уул аймаг руу 2 удаа, Сэлэнгэ аймаг, Дундговь аймаг, Хэнтий аймаг | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон эмч, ажилчдын үйлчилгээнд нийт 2096 км улсын бүртгэлийн 9913 УАМ дугаартай Соната автомашинаар үйлчилгээнд явсан. | |
| 4.1.26 Засвар, цэвэрлэгээ, тохижилт, ногоон байгууламж | Улсын төсөв хагас жил | Лабораторийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл байдлыг хангах, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах | 10 | 15 | Цас орох бүрт гадна талбайг 15 удаа цас цэвэрлэж ажилласан.<br><br>2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр байгууллагын аж ахуйн хогийг ХУД-ийн нийтлэг үйлчилгээний газарт захиалга өгч 5 тн хог, 2025 оны 5 сард 4 тн хог нийт 9 тн хогийг тус тус ачуулж, тус хогийн цэгийг цэвэрлэсэн.<br><br>2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хаварын бүх нийтийн цэвэрлэгээг байгууллагын гадна баруун тал, автомашины зогсоол хогийг цэвэрлэсэн.<br>2025 оны 01 дүгээр сард Санхүү, аж ахуй, үйлчилгээний нэгжийн хамт олон оффисын гадна нийтийн эзэмшлийн талбайг их цэвэрлэгээ хийж ажилласан. | 100% |
| 4.1.27 Засвар, цэвэрлэгээ, тохижилт, ногоон байгууламж | Улсын төсөв хагас жил | Лабораторийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл байдлыг хангах, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах | 0 | 3 | 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр оффисын баруун талын халзарсан шороо тэгшлэн, байгалийн чулуугаар хашлага, цэцгийн мандалын суурь, ус зайлуулах хамгаалалт, сувагыг цементэлсэн.<br>2025 оны 06 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд байгууллагын гадна талын ногоон байгууламжинд цэцэг, зүлэгний | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үр суулгаж, аж ахуйн аргаар модон хайс, байгалийн чулуугаар цэцгийн мандалын суурь, хар шороогоор суурь, ус зайлуулах хоолойг хийж гүйцэтгэсэн. | |
| | | | 0 | 1 | Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 02 дугаарын сарын 24-ны өдрийн А/71 тоот тушаалаар “Гоц халдварт өвчний лаборатори”-ийн их засварын ажлын зураг, төсвийг Онолт Од ХХК-иар хийлгэж ажиллалаа. | 100% |
| | | | 0 | 1 | Байгууллагын үйлчилгээнд Улсын бүртгэлийн 99-13 УАМ автамашинд цэнхэр дугаар авсан. | 100% |
| | | | 0 | 1 | Улаанбаатар хотоос Дархан-Уул аймаг руу лабораторийг нүүлгэх гэж байгаатай холбоотойгоор Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1 дүгээр баг Бэрх хайрханы орчимд 8.1 га газрын нэгж талбарын зурагыг хийлгэж ирсэн. | 100% |
| 4.1.28 Гадаад, дотоодын сургалт зохион байгуулах | Улсын төсөв хагас жил | Лабораторийн ажилчдыг гадаад, дотоодын сургалтанд хамруулах | 0 | 1 | 2025 оны 02 дугаар сарын 19-23-ны хооронд ерөнхий инженер А.Болдбаатар, био-аюулгүйн ажиллагаа, чанарын менежер П.Дулам нар БНХАУ-ын Чунчин хотын Аудеон био үйлдвэр, Ланжоу хотын ДАЭМБ-ын шүлхийн лавлагаа лаборатори, Бээжин хотын Мал, Амьтны өвчин судлалын хүрээлэн, Нийгмийн эрүүл мэндийг хянан хамгаалах инноваци технологийн лаборатори BSL-III зэрэглэлийн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлдвэр, лабораториудтай танилцах сургалтанд хамруулсан. | |
| | | | 0 | 1 | 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Санхүү, аж ахуй, үйлчилгээний хамт олон санаачлан “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-ийн бэлтгэл ажлыг хангах үүднээс Нийслэлийн Онцгой байдлын газрын хурандаа н.Мөнхбат гамшгийн үед албан байгууллага яаж ажиллах чиглэлээр сургалт хийж ажилласан. | 100% |
| 4.1.29 Гадаад, дотоодын сургалт зохион байгуулах | Улсын төсөв хагас жил | Лабораторийн ажилчдыг гадаад, дотоодын сургалтанд хамруулах | 0 | 1 | Мал эмнэлгийн Ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/34 “Команд штабын сургууль зохион байгуулах тухай” даргын тушаал, УМЭАЦТЛ-ийн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/11 “Команд штабын сургууль зохион байгуулах тухай” захиралын тушаалын дагуу 2025 оны 03 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд команд штабын даргаар батлуулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Мөн захиргааны хэм хэмжээний нийт 19 акт, салбарийн хэмжээнд мөрдөгдөж байгаа 12 хуулиуд, УМЭАЦТЛ-ийн захиралын нийт 38 тушаал, журам, заавар, гарын авлагыг нэгтгэн 3 хавтас үүсгэсэн.<br><br>Мөн үзүүлэх сургуулилтын явцын бүхий л баримт бичгийг архивын нэгж болгон боловсруулсан. | 100% |
| | | | 1 | 1 | 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр байгууллагын ХАСХОМ-ын өөрчлөлт, | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинэчлэлийн талаар цахим сургалт, 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Төв аймгийн Төрийн архивын газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг зааврын шинэчлэлт”-тэй холбоотой 2 цагийн цахим сургалтанд хүний нөөцийн мэргэжилтэн М.Ренчинмядаг, захирлын туслах Л.Цэрмаа нар амжилттай сургалтанд хамрагдсан. | |
| 4.1.30 Гадаад, дотоодын сургалт зохион байгуулах | Улсын төсөв хагас жил | Лабораторийн ажилчдыг гадаад, дотоодын сургалтанд хамруулах | 0 | 1 | 2025 оны 05 дугаар сарын 28-29-нийн өдрүүдэд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” сэдэвт зөвлөгөөнд Санхүү, аж ахуй, үйлчилгээний нэгжийн дарга Б.Цэрэндаваа (Төрийн албаны хууль, тогтоомжийн хэрэглээ, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн хэрэглээ, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомжийн хэрэглээ, МУ-ын Төрийн албаны шинэтгэл-үр дүн, Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал, Төрийн албаны санхүүжилт, төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа) оролцож Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудын үзэл баримтлал, салбарийн хэмжээнд одоо мөрдөгдөж байгаа эрх зүйн орчин, төсөв санхүүгийн чиглэлээр цаашид шинэлэх гэж байгаа хуулиуд, дүрэм, журамд санал өгсөн. | 100% |
| | | | 0 | 1 | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт улсын үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд Төв аймгийн Төрийн архивын газрын дарга Д.Оюунтуяа, архивын | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэргэжилтэн Ц.Анхбаяр, Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын гишүүн н.Баттуяа нар байгууллагын хамт олонд “Баримт бичгийн стандарт”, “Архивын хадгаламжийн нэгж бүрдүүлэлт” сэдвийн хүрээнд 2 цагийн сургалтыг зохион байгуулсан. | |
| 4.1.31 Мал эмнэлгийн лабораторийг чадавхжуулах (сургалт, итгэмжлэл) | | 1. Орон нутгийн эмч нарт сургалт, арга зүйн зөвлөмж өгсөн тоо<br>2.Дадлагажуулсан шинжлэгч эмчийн тоо | 1.21<br>2.5 | 1.21<br>2.8 | ХПӨОТЛ-ийн шинжлэгч эмч нар 5 өвчинөөр илтгэл бэлтгэн 21 аймаг, нийслэлийн 135 эмч нарт сургалтыг цахимаар болон ажлын байранд зохион байгуулав. ХПӨОТЛ-д Ховд, Дундговь, Говьсүмбэр, Хөвсгөл, Завхан, Төв, Дорноговь аймгуудын, Ийлдэс,паразит судлагч болон Нян судлагч эмч нар 7-14 хоногийн ажлын байрны сургалтанд хамрагдсан. | |
| 4.1.32 Мэдлэг, ур чадвараа ахиулах | | Тархвар зүйн чиглэлээр гадаадад 1, дотоод 1 тус тус мэргэжилтэн сургалтад оролцов. | 1.1 | 1.4 | Тайлант хугацаанд дараах сургалтад хамрагдсан. Үүнд:<br>-МЭЕГ болон Бодлого судлалын төвөөс 2025 оны 02-р сарын 10-15-ны өдрүүдэд хамтран зохион байгуулсан “Халдварт, паразит өвчний гаралт, тархалтын зураглал хийх, зурган мэдээлэл гаргах програм эзэшүүлэх” сэдэвт сургалтанд 2 мэргэжилтэн хамрагдсан.<br>-MNS ISO/IEC 17025:2018 болон MNS ISO 19011:2016 стандартын сургалтад 1 мэргэжилтэн хамрагдсан.<br>- Архивын материал бэлтгэх танхимын сургалтад бүх ажилчид идэвхтэй оролцсон | |